



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 157

Булагтай

Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 16 зүйл, 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 29 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Төлөөлөгчийн "Ёс зүйн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн заалт, чиглэлийг Төлөөлөгч нарт сайтар сурталчлан, хэрэгжүүлэх ажлыг байнга эрчимжүүлж, ёс зүйн дүрмийн биелэлт үр дүнг жил бүр дүгнэж ажиллахыг дээр ёс зүйн хороог чиг үүргээ чанартай гүйцэтгэхэд удирдлага зохион байгуулалтаар дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.


3. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн заалт бүрийг чанартай хэрэгжүүлж, Төлөөлөгчийн сонгуульт үүргийн биелэлтийг жигд хангуулж ажиллахыг Нутгийн удирдлага, хууль эрх зүй, Ёс зүйн хорооны дарга /Ч.Оюун/, гишүүд, Ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 01-р сарын 24-ний өдрийн
154 дүгээр тогтоолын хавсралт.



ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Дүрмийн зорилго нь:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс иргэд сонгогчид, сонгогдсон Хурлын байгууллагынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж, ёс зүйн хэм хэмжээг сахиж, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

Хоёр. Дүрмийн эрх зүйн үндэслэл нь

Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал, Мэдээлэл авах эрхийн тухай, Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын тухай, Нийтийн сонсголын тухай, Зөрчлийн тухай, Захиргааны ерөнхий хууль зэрэг хуулиудыг судалж мөрдөж хэрэгжүүлэх нь ёс зүйн аливаа алдаа дутагдал, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, ёс зүйн дүрмийн хууль эрх зүйн үндэс болно.

Гурав. Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ:

3.1. Төлөөлөгч нь үйл ажиллагаандаа дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө.

3.1.1. Сонгуульт үүргээ биелүүлэх, бусадтай харилцах, үзэл бодлоо илэрхийлэх, албан ажил, зан үйлдэлдээ хууль ёсоо дээдэлж мөрдөнө.

3.1.2. Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

3.1.3. Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж сахина.

3.1.4. Сонгогч иргэддээ чин сэтгэлээсээ үйлчилж тэдний хэлсэн үг, гаргасан санал гомдол, хүсэлт шүүмжлэлийн мөрөөр ажил зохион холбогдох албан тушаалтанд уламжилж хариу авч иргэддээ мэдээлж ажиллана.

3.1.5. Гэр бүл, үр хүүхэд, бага балчир насныхны эрүүл чийрэг хүмүүжилд байнга анхаарч хүчирхийлэх, зодон гэмтээх тэдний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлж, гэр бүл, хүүхдийн эрхийг хамгаалж ажиллана. Жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байна.

3.1.6. ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчид, Хорооны хуралд идэвхтэй оролцож, хуралдааны дэгээ мөрдөж, хэлэлцэж байгаа асуудлаар асуулт тавьж, горимын санал гаргаж, шийдвэрийг ажил хэрэгчээр батлахын дээр, шалтгаангүйгээр хурал таслах, хурал хаях, хурлаа зогсоохыг шаардах, хувийн явцуу үзэл бодлоо тулгахгүй байна.

3.1.7. Гаргасан шийдвэр, тавьсан зорилтоо иргэд, сонгогчдод байнга таниулж санал бодлыг нь уламжилж, шийдвэрийн биелэлтээр хяналт шинжилгээ хийж холбогдох шатны хурлаар хэлэлцүүлэхээр санал санаачилга гаргана.

3.1.8. Ядуурал, ажилгүйдлийг дэс дараатай бууруулах, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн ажил амьдралд анхаарч туслах, байгаль цаг уур болон болзошгүй аюулаар хохирсон иргэдийн сэтгэл санааг дэмжих зэргээр нийгмийн сайн үйлсийг өрнүүлж ажиллана.

3.1.9. Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн чиглэлээр өөрийгөө чанартай бэлтгэж, холбогдох хууль тогтоомжийг судлах, мэргэжлийн хүмүүстэй уулзаж ярилцах, иргэдийнхээ санал бодлыг тандах, холбогдох ном, гарын авлага уншиж судлах замаар хуралдаандаа ажил хэрэгч, мэдлэгтэй идэвхтэй оролцоно.

3.1.10. Албан болон сонгуульт үүргээ гүйцэтгэхдээ гадаад дотоодын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, үгсэн тохирох, тэднээс бэлэг шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах ах дүү, хамаатнаа тендерт ялуулахыг оролдох зэргээр ашиг сонирхлын зөрчил гаргахаас байнга сэргийлж ажиллана.

3.1.11. Иргэд сонгогчидтой харилцахдаа үндэс угсаа, нас хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, улс төрийн намын харьяалал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан хандахгүй, эрх тэгш харилцаж үйлчилнэ.

3.1.12. Төлөөлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ бүх иргэдийг нэр төртэй төлөөлж, орон нутгаа хөгжүүлэх, хүн ардаа ажил үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхэд анхаарч, хүний сайн сайхны төлөө санаж сэдэж, зүтгэж тэмүүлж манлайлж ажиллана.

3.1.13. Сонгуульт болон албаны аливаа ажилд хөнгөн гоомой хандах, үл тоомсорлох, биеэ тоох, цахимаар бусдыг гүтгэж, нэр төрд нь халдах, хүнд суртал чирэгдэл гаргахгүй байна.

3.1.14. Архидан согтуурах, худал хуурмаг амлалт өгөх, намчирхах, бусдыг хууль бусаар турхирах, худлаа хэлэх зэрэг ёс зүйн алдаа гаргахгүй байна.

3.1.15. Төлөөлөгч өөрийн ба гэр бүлийн гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, орлого зарлагад гарсан их хэмжээний өөрчлөлтөө цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж мэдүүлж, тайлбарлаж байна.

3.1.16. Төлөөлөгч өөртэй нь буюу гэр бүл, хамаатан садны ашиг сонирхолтой нь холбоотой асуудал хэлэлцэх хуралдаанд өөрийн саналаараа оролцохгүй байхаа илэрхийлнэ.

3.1.17. Байгууллага хамт олны болон аль нэг албан тушаалтан, иргэний нэр төр, нууцыг хамгаалж, гүтгэх, хилсээр муулах зэргийг гаргахгүй байна.

3.1.18 Төлөөлөгч үүргээ гүйцэтгэхдээ төрийн байгууллага, нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтнуудаас албан ажлын хүрээнд зөвхөн хуулийн дагуу зөвлөмж дэмжлэг авна.

3.1.19. Хурлын байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чанартай биелүүлж хариуг өгдөг байна.

3.1.20 ИТХ-ын шийдвэрээр тогтоосон дэг журмаа сахин биелүүлэхийн хамт хууль зөрчсөн, байгаль орчноо хамгаалах, газрын баялаг, ашигт малтмалын зөвшөөрөл олгох, орон нутгийн сангийн хөрөнгийг зарцуулах асуудалд шударга бус хандах явдалтай эвлэрдэггүй байна.

3.1.21 Тухайн шатны Засаг дарга, нутгийн захиргааны албан тушаалтанд хувийн эрх ашгийн үүднээс шахалт дарамт үзүүлэх, ашиг сонирхлоо тулгаж илэрхийлэх зэрэг хууль бус шаардлага тавихгүй байна.

3.1.22 Иргэний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж нутаг дэвсгэрийн хэмжээний ажил үйлчилгээг сайжруулах, дутагдал доголдлыг арилгуулах, хурлын шийдвэрийг биелүүлэх талаар Засаг дарга, түүний орлогч, нутгийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтанд шаардлага, асуулга тавьж, хариу авч иргэддээ мэдээлдэг байна.

Дөрөв: сумын ИТХ-ын ёс зүйн хороог байгуулах, түүний зохион байгуулалт үйл ажиллагааны чиглэл

4.1. ИТХ-ын Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлэх, зөрчил дутагдлыг арилгуулах, шуурхай шийдвэрлэх зорилгоор үнэнч шударга, ажил хэрэгч, хариуцлагатай хүмүүсийг оролцуулсан 5-7 хүний бүрэлдэхүүнтэй "Төлөөлөгчийн ёс зүйн хороо"-г ИТХ-ын хуралдаанаар байгуулна.

4.2. Төлөөлөгчийн ёс зүйн хорооны тоо бүрэлдэхүүнийг тухайн шатны ИТХ өөрөө шийдвэрлэнэ.

4.3. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт, зарчмыг тусгасан "Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм"- ийг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж тогтоол гаргана.

4.4. Төлөөлөгчийн ёс зүйн хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны хурлаас сонгоно.

4.5. Төлөөлөгчийн ёс зүйн хороо нь энэ дүрмийн заалтын дагуу Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг жил жилээр дүгнэж хорооны хурлаар хэлэлцэж байна.

4.6. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт, шүүмжлэл, ИТХ-ын удирдлагуудаас өгсөн чиглэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан асуудлыг нэг бүрчлэн шалган тогтоосны үндсэн дээр Хорооны хурлаар хэлэлцэнэ.

4.7. Асуудлыг хэлэлцэхийн өмнө уг асуудлаар судалгаа хийх, нотлох баримтуудыг цуглуулах, /Захиргааны ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн дагуу/ хөндлөнгийн хүмүүсийн санал гомдлыг тандах замаар хорооны гишүүдийг тодорхой чиг үүрэгтэйгээр ажиллуулна.

4.8. Төлөөлөгчийн талаар гарсан гомдол, шүүмжлэлийг үндэслэлтэй гэж үзэх баримт нотолгоо бүрдсэн нөхцөлд уг Төлөөлөгчийн санал бодлыг сонсоно.

4.9. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нээлттэй, хаалттай хийхээ хорооны хуралд оролцсон Төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.10. Хорооны хурал нь уг Төлөөлөгчийн талаар нухацтай ярилцаж ёс зүйн хэм хэмжээг яаж зөрчсөн, хор холбогдол нь хир болох, санаатай үйлдсэн давтсан эсэхийг ярилцаж зөвлөмж гаргана. Зөвлөмж нь захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлд заасан шаардлагуудтай нийцсэн байна.

4.11. Хорооны зөвлөмж нь хурлын протоколоор баталгаажна. Зөвлөмж шийтгэвэр нь захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан байна.

4.12. Төлөөлөгчдийн ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдсон бол ёс зүйн хорооноос доор дурдсан хариуцлага тооцуулахаар ИТХ-ын хуралдаанд танилцуулна. Төлөөлөгчийн шийтгэврийн эцсийн шийдвэрийг ИТХ гаргана.

4.12.1. Уучлалт гуйлгах

4.12.2. Сануулж дутагдлыг ойлгуулах

4.12.3 Холбогдох шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бол Төлөөлөгчдөөс огцруулах

4.12.4. Зөрчил дутагдлыг дахин давтан гаргасан бол дараагийн сонгуульд нэрийг нь дэвшүүлэхээс татгалзах саналыг улс төрийн намууд, зохих шатны удирдлагууд, сонгогч хамт олонд нь мэдэгдэх.

4.13. Хорооны гишүүд уг асуудлыг хэлэлцэж шийдэхдээ хууль дээдэлсэн, үнэнч шударга, хариуцлагатай ажиллана.

4.14. Ёс зүйн хороо нь хийсэн ажлынхаа тайланг Хорооны хурлаар хэлэлцэн жилд нэг удаа ИТХ-ын Хуралдаанд танилцуулна.

4.15. Төлөөлөгчийг гүтгэх, нэр төрд нь харшлах үйлдлийг тогтоон, Төлөөлөгчийн нэр хүнд байр суурийг хамгаална.

4.16. Хорооны ажлын тайлан мэдээ, хурлын протокол, иргэд, хамт олноос ирүүлсэн, баримт бичгийг жилээр нэгтгэн архивын нэгж болон ИТХ-ын ажлын албанд өгнө.

Тав: ИТХ-ын удирдлагаас хийх ажил

5.1. Сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг биелүүлэхийг нийт Төлөөлөгчдөөс шаардаж ёс зүй, түүний хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга замын талаар сургалт, семинар, хэлэлцүүлэг хийж байна.

5.2. Ёс зүйн хорооны дарга, гишүүдийг ажиллах боломжоор хангаж үүргээ биелүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч шаардлагатай төсөв хөрөнгийг гаргана.

5.3. Ёс зүйн асуудлаар холбогдох албан тушаалтан, байгууллагаас тодруулга, лавлагаа авах хүсэлт саналыг ИТХ-аас албан бичгээр уламжилж хариуг авна.

5.4. Төлөөлөгчийн ёс зүйн хорооны санал санаачилгаар тайланг болон Төлөөлөгчийн асуудлаар ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж шийдвэр гаргана.

Зургаа: Бусад асуудал

6.1. Ёс зүйн хэм хэмжээ гэдэг нь хууль дүрмээр олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний байгууллага, иргэд, сонгогчид хамт олны хүрээнд дагаж мөрдвөл зохих хэм хэмжээ, зан үйлийн нийлбэр цогц мөн. Төлөөлөгчийн ёс зүйн дүрмээр заасан хэм хэмжээг санаатай буюу санамсаргүй зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс дүрмээ зөрчсөн гэж үзнэ. Хууль болон энэхүү дүрэмд заасан эрх үүргээ зориуд буюу байнга биелүүлж гүйцэтгээгүй бол эс үйлдэхгүй гэнэ. Сонгуульт үүрэг, эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэн хэрэглэх, хурлын үйл ажиллагаа, сонгогч иргэдтэйгээ тогтмол оролцож харилцаагүй санаатайгаар зайлсхийсэн бол зөрчсөн үйлдэл гэж ойлгоно. Их хэмжээний орлого зарлагын өөрчлөлт гэж сарын үндсэн цалин буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуульд заасан хэмжээгээр нэмэгдүүлснийг авч үзнэ.

6.2. Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд Төлөөлөгч өөрөө ойлгон ухамсарлаж нийт Төлөөлөгчдийн өмнө буюу Хорооны хурал дээр уучлалт гуйсан бол Хурлын протоколд тэмдэглэж нийтэд мэдээлнэ.

.....ооо.....